

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2025/0171-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2025 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Г.Хатанбаатар

Утас: 70272287 Цахим хаяг: khatanbaatarga@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зүүнмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuvaudit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.03.21 № 01/аен

таний _____ -ны № _____ -т

ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН
ЗАСАГ ДАРГА Т.ГАНСҮХ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төв аймгийн Сэргэлэнг сум нь тайлант онд орон нутагт төвлөрүүлэх 22,301,470.7 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 21,165,381.6 мянган төгрөг төвлөрүүлж, биелэлт 94,9 хувьтай орон нутгийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 1,136,089,1 мянган төгрөг тасарсан байна. Үүнд орон нутагт төвлөрүүлэх 2 нэр төрлийн орлогыг 1,136,089.1 мянган төгрөгөөр, аймагт төвлөрүүлэх 1 нэр төрлийн орлогыг 61,949.4 мянган төгрөгөөр, улсад төвлөрүүлэх 1 нэр төрлийн орлогыг 45,468,3 мянган төгрөгөөр, нийт 1,243,506.8 мянган төгрөгөөр орлого тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг дарга тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн төвөөс сум хүртэлх хатуу хучилттай 4,2 км замын ажлыг 5,779,797.4 мянган төгрөгөөр, 50 хүүхдийн иж бүрэн тавилгатай дотуур байр 2,094,017.8 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна.

4125065-3

Аудитын гол асуудал

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг дарга тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 329,959.9 мянган төгрөгөөр наадмын талбайн тохижилт, цэвэр усны шугамтай 2 ширхэг нийтийн бие засах газар барих ажил, 225,287.3 мянган төгрөгөөр Соёлын төвийн гадна тохижилт, 261,849.5 мянган төгрөгөөр төрийн албан хаагчдын орон сууц, 199,171.0 мянган төгрөгөөр Баянбүрд 1-р багт Ахуйн үйлчилгээний барилга хийж гүйцэтгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус сумын 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд 8 хөтөлбөр, 108 арга хэмжээг хэрэгжүүлж 97,7 хувьтай дүгнэгдсэн байна. Хөтөлбөр арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 75,0 хувь байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/ мянган төгрөгөөр/				
Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		8,072,279.4	8,025,197.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	6,926,431.9	3,398,593.6
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	1,054,362.6	4,525,478.5
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	91,484.8	101,125.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		3,204,906.2	5,071,290.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	3,204,906.2	5,071,290.7
39200	Биет хөрөнгө		3,179,007.2	5,039,119.9
39300	Биет бус хөрөнгө	13	25,899.0	32,170.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		11,277,185.6	13,096,488.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		41,096.0	129,420.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	41,096.0	129,420.0
41300	Өглөг	17а, 17б	41,096.0	129,420.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		11,236,089.5	12,967,068.6
51	Засгийн газрын хувь оролцоо		11,236,089.5	12,967,068.6
51100	Засгийн газрын оруулсан капитал		899,281.1	899,281.1
51200	Хуримтлагдсан үр дүн		10,302,974.2	12,033,953.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		33,834.3	33,834.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		11,277,185.6	13,096,488.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/ мянган төгрөгөөр/				
Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		29,096,694.7	23,027,299.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО		15,754,636.2	20,717,823.0
110	Орлогын албан татвар		5,054,484.3	8,570,931.0
1100	Хувь хүний орлогын албан татвар		5,065,484.3	8,570,931.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-11,000.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар		9,108,976.1	11,042,523.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж		1,591,175.8	1,104,368.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,804,805.7	1,182,541.2
120	Нийтлэг татварын бус орлого		1,764,805.7	1,180,541.2
122	Тусламжийн орлого		40,000.0	2,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		11,537,252.8	1,126,935.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	25,042,153.0	20,907,639.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ		23,352,893.0	18,330,681.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,811,121.4	2,424,941.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		678,229.1	935,731.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		85,356.2	119,917.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		49,923.9	296,958.4
2104	Хангамж, бараа материалын зардал		81,274.6	76,975.1
2105	Нормативт зардал		20,413.7	20,262.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		28,043.0	81,790.0
2107	Томилолт, зочны зардал		1,821.6	7,356.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		18,098.9	24,931.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		847,960.4	861,018.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		21,541,771.6	15,905,740.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		1,689,260.0	2,576,958.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		4,054,541.7	2,119,659.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		162,081.3	388,680.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)+(V)		3,892,460.4	1,730,979.1

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,333,060.3	7,333,060.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	10,568.9	10,568.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,343,629.2	7,343,629.2
9	Тайлант үеийн үр дүн	3,892,460.4	3,892,460.4
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,236,089.5	11,236,089.5
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	11,236,089.5	11,236,089.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-0.1	-0.1
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,236,089.4	11,236,089.4
19	Тайлант үеийн үр дүн	1,730,979.1	1,730,979.1
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	12,967,068.6	12,967,068.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	28,923,953.4	22,629,255.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	15,754,636.2	20,717,823.0
110	Орлогын албан татвар	5,054,484.3	8,570,931.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	5,065,484.3	8,570,931.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-11,000.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар	9,108,976.1	11,042,523.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,591,175.8	1,104,368.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	897,793.8	53,395.6
1181	Газрын төлбөр	461,524.0	654,253.2
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	231,858.0	396,720.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,632,764.4	639,927.1
120	Нийтлэг татварын бус орлого	1,592,764.4	639,927.1
122	Тусламжийн орлого	40,000.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,536,552.8	1,271,505.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,184,039.6	17,908,302.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,184,039.6	17,908,302.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,642,713.3	2,003,996.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	663,602.5	936,321.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,301.6	114,703.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,310.6	281,434.6
2104	Хангамж, бараа материалын зардал	55,034.3	71,159.5
2105	Нормативт зардал	20,099.4	16,360.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,589.4	99,553.2
2107	Томилолт, зочны зардал	2,130.6	7,356.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,354.4	31,392.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	717,290.5	445,715.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,541,326.3	15,904,306.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,739,913.8	4,720,952.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,659,310.9	8,248,068.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,659,310.9	8,248,068.7
2200	Дотоод эх үүсвэрээр	3,659,310.9	8,248,068.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-3,659,310.9	-8,248,068.7
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-110,170.0	-722.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	110,170.0	722.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,970,432.9	-3,527,838.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,955,999.0	6,926,431.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,926,431.9	3,398,593.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,663,227.4	9,494,459.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,771,303.2	1,613,535.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,751,695.2	1,594,678.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	823,271.8	791,777.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,909.0	102,051.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	322,589.6	275,766.4
2104	Хангамж, бараа материалын зардал	45,180.0	44,716.6
2105	Нормативт зардал	5,000.0	2,531.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	83,706.0	82,973.8
2107	Томилолт, зочны зардал	6,516.0	6,336.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,561.0	29,617.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	326,961.8	258,908.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,608.0	18,857.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,608.0	18,857.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,791,924.2	7,880,201.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	100,000.0	722.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,663,227.4	10,143,805.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	578,043.0	-
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,245,219.5	10,090,613.5
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,839,964.9	53,191.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	137,051.5
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	643,844.5
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	62	62
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	30	30
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	30	30

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	295,417.2	709,619.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	295,417.2	345,733.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	229,335.4	245,829.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,690.3	81,356.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,003.8	5,352.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	5,668.2
2104	Хангамж, бараа материалын зардал	-	14,013.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	355.9	-
2107	Томилолт, зочны зардал	-	1,020.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	-	1,307.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	211,285.4	137,111.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,081.8	99,904.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	14,892.3
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	66,081.8	85,012.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	363,886.3
2200	Дотоод эх үүсвэрээр	-	363,886.3
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	295,417,249.5	709,619,710.7
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	295,417,249.5	709,619,710.7

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулсан алдаа гараагүй байна.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1,243,506.8 мянган төгрөгийн орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр тасалсан зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

Аудитаар нийт 1,243,506.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 1,243,506.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүллээ.

Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1		1					
2	Засаг даргын тамгын газар	1	1				1		
3	Сэргэлэн нутгийн хөгжил ОНӨТҮГ	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Эмийн эргэлтийн сан	1		1					
6	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
	НИЙТ	6	1	5			1		

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсанг ай холбоотой		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Засаг дарга	0	0					0	-				
Орон нутгийн хөгжлийн сан	1	50,546.80	1	50,546.8	0		1	50,546.8				
Дүн	1	50,546.8	1	50,546.8	0	-	1	50,546.8	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	1	1,243,506.8		-		-	1	1,243,506.8
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	2	5,500.0	1	5,500.0			1	-
Засаг даргын тамгын газар	10	442,357.8	4	1,447.8	3	220,473.0	3	220,437.0
Хоршоо хөгжүүлэх сан	1	-					1	-
БНСБС	1	-					1	-
Эмийн эргэлтийн сан	3	1,177.5			1	1,100.0	2	77.5
Дүн	18	1,692,542.1	5	6,947.8	4	221,573.0	9	1,464,021.3

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Засаг дарга	1	-			1	0		
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	-					1	-
Засаг даргын тамгын газар	1	-					1	-
Дүн	3	-	0	-	1	-	2	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	3	-	-	-	1	-	2	-